



ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, багасгажуулалт, хориний болон
бизнесийн үзүүлэлт, зондох үйлчилгээ

Монгол Улс Улаанбаатар хот-Бабийн
Лэнгийн дүүрэг Амарсангааны тэмж-8
Утас: 70003461 Телефон: +976 31 70005105
Факс: +976 31 70005405
E-mail: info@daalayvan.mn
Web-sajt: www.daalayvan.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТУШИГ-УУЛ ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДЭД

Хязгаарлалтгүй санал дүгнэлт

Бид 2018 оны 12 дугаар сарын 31-эрх санхүүтийн байдлын тайлан, жилийн эцэсэрх орлогын долгэрөнгүй тайлан, өмчийн оөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдолтой нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйт багтаасан санхүүтийн тайлангийн тэмдэглээс бүрдсэн Түшиг-Уул ХК-ийн (РД: 2024306) санхүүтийн тайланд аудит хийж гүйцэтгээ.

Бидний дүгнэлтээр Түшиг-Уул ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний одрийн байдлаарх санхүүтийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн оөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүтийн Тайллагнальн Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн Сайдаас баталж, гаргасан журам зааврын дагуу үнэн зөв илэрхийлгэдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл


Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг өнэхүү тайлангийн санхүүтийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсгэгт харуулсан. Бид санхүүтийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгэр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын итогийгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалтай бөгөөд зохицой гэж бид үзэж байна.

Санхүүтийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлатгалгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхээд удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаа зогсоох, ингэхээс бор сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын сууриний талаар нэмэлт тодруулга хийн).



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлантналын үйл явцад хяналт тавих үүргийг хөсөлж.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

Гүйцэтгэх удирдлагатай харилцааны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох компанийн хувьцаа эзэмшигчдийн хүснэгтийн дагуу бэлтгэсэн ба тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа таалын өмнө ямар нэг хариуцлага хүлэхгүй болно.

ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

**2019 ОНЫ 4 ДҮГЭЭР
САРЫН 30-НЫ ӨДӨР**